

Энэхүү ТМТ нь 2015 оны 9 сарын 30-ны Англи хувилбарын орчуулга болно.



Монгол Улс: Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр

Төслийн нэр	Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр
Төслийн дугаар	49210-001
Улс орон	Монгол Улс
Төслийн статус	Санал
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Зээл
Хөрөнгийн эх үүсвэр / Хэмжээ	Зээл: Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр Энгийн хөрөнгийн эх үүсвэр 150 сая ам.доллар
Стратегийн зорилт	Оролцоог хангасан эдийн засгийн өсөлт
Хөдөлгөгч хүчин зүйл	Засаглал ба чадавхийн хөгжил
Салбар / Дэд салбар	Төрийн удирдлага – Нийгмийн хамгаалал
Жэндэрийн тэгш байдал ба оролцоо	Жэндэрийн зарим асуудал
Агуулга	Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын төсвийн алдагдлыг бууруулах ажлын хүрээнд хэрэгжих, (i) төсвийн бодлогын удирдлагыг сайжруулах, (ii) нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг зорилтот хэсгүүдэд, нэгтгэхэд чиглэсэн бодлого, журмуудыг боловсруулах шинэтгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Эдгээр шинэтгэлээр дамжуулан, нийгмийн халамжийн санхүүжилтийг тогтвортойгоор хангахад хөтөлбөр хувь нэмэр оруулна.
Төслийн үндэслэл ба Улс/Бүсийн стратегитай уялдсан байдал	Хөгжлийн саад бэрхшээл ба боломж. Нийт 3 триллион ам.доллараар үнэлэгдэх Монгол Улсын эрдэс баялгийн нөөц их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ыг татсаар ирсэн ба 2011-2012 онд ГШХО-ын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийн 40%-тай тэнцүү болж, Монгол Улс эдийн засгийн хөгжлийн хурдаараа дэлхийд тэргүүлсэн аж. Эдийн засаг хурдацтай хөгжсөнөөр, Монгол Улс 2011 оны сүүлээр дунд орлоготой улсын ангилалд орсон ба нэг хүнд ногдох орлого 2013 онд 4,000 ам.доллар хүрсэн. Тус улсын хувьд хэтийн төлөв ихээхэн таатай байгаа бөгөөд одоо хэрэгжиж буй уул уурхайн томоохон төслүүдийн орлого

төвлөрснөөр 2020 он гэхэд төсөв болон төлбөрийн тэнцэл ашигтай болох төлөвтэй байна.

Монгол Улсын эдийн засаг төдийлөн төрөлжөөгүй тул ГШХО-аар голлон санхүүжигддэг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай байна. Үүний улмаас, эдийн засаг гадаад хүчин зүйлд өртөмтгий байгаа ба нэн ялангуяа түүхий эдийн үнэ, худалдааны түнш орнуудын эдийн засгийн мөчлөгийн нөлөө өндөр байна. Таваарын үнийн уналт үргэлжилж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын өсөлт удааширч буй өнөөгийн таагүй гадаад орчин нь Монгол Улсын эрдсийн олборлолт болон төсвийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлсөөр. Үүний зэрэгцээ, улс төрийн байдал тогтворгүй байж, хөрөнгө оруулагчдын итгэл суларснаас ГШХО 2013 онд 55 хувиар, 2014 онд 80 хувь буурч, их хэмжээний орлого бүрдүүлэх төслүүдийн хэрэгжилт удаашрав.

Ийм нөхцөл байдалд, ДНБ-ийн өсөлт 2011 онд үзүүлсэн 17.3 хувийн дээд хэмжээнээсээ огцом буурч эхэлсэн тул Засгийн газар 2012 оноос эхлэн төсөв, мөнгөний тэлэх бодлого баримталсан.

Үр нөлөө	Төсвийн алдагдлыг бууруулах арга хэмжээний ядуу иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулна (2015-2017 оны Макро эдийн засгийг тогтворжуулах төлөвлөгөө).
Үр дагавар	Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд үргэлжилнэ
Үр дүн	1. Төсвийн бодлогын удирдлага сайжирна 2. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг зорилтот хэсгүүдэд хүргэх, нэгтгэхэд чиглэсэн бодлого, журам сайжирна

Газарзүйн байрлал

Хамгааллын төрөл

Байгаль орчин	С
Албадан нүүлгэн шилжүүлэлт	С
Уугуул иргэд	С

Байгаль орчин, нийгмийн асуудлын товчоон

Байгаль орчны асуудал	
Албадан нүүлгэн шилжүүлэлт	
Уугуул иргэд	

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба зөвшилцөл

Төслийн төлөвлөлтийн үед

Төслийн хэрэгжилтийн үед

АХБ-ын хариуцсан Ажилтан Ёланда Фернандез Ломмен

АХБ-ны хариуцсан Газар Зүүн Азийн газар

АХБ-ны хариуцсан Хэлтэс Захирлын ажлын алба, Зүүн Азийн газар

Хэрэгжүүлэгч агентлаг **Сангийн яам**, Засгийн газрын байр – II, Нэгдсэн үндэстний гудамж - 5/1, Улаанбаатар-210646, Монгол Улс

Хуваарь

Концепцийг батлах 2015 оны 6 сарын 18

Урьдчилсан судалгаа 2015 оны 6 сарын 10-24

Менежментийн хяналтын уулзалт 2015 оны 8 сарын 12

Батлагдсан 2015 оны 9 сарын 29

Сүүлд хийсэн хяналт -

Сүүлд хийсэн нэмэлт 2015 оны 9 сарын 11

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг: ТМТ нь одоогоор хэрэгжиж байгаа ажлын тухай байдаг тул тайлангийн анхны хувилбарт зарим мэдээлэл багтаагүй байж болох ба бэлэн болсон үед нь нэмж оруулдаг. Санал болгож байгаа төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)–г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа нэгэн амлалт, баталгаа өгөхгүй. АХБ нь өндөр чанарын мэдээллийн контент гаргахыг эрмэлзсэн хэдий ч тухайн мэдээллийг “байгаагаар нь” ойлговол зохих бөгөөд арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүй. Нэн ялангуяа, тайланд агуулагдсан мэдээлэл үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн болох талаар ямар нэгэн баталгаа эсвэл мэдэгдэл гаргаагүй болно.